

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД
ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ

2025 оны *02* сарын *04* -ны өдөр

Дугаар *54-040/2025* Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын нийслэл, Хан-Уул дүүргийн 11 дүгээр хороонд баригдсан дунд төвөгшилтэй ангиллын зорьтой 7 давхар, 47.7м*26.7м (А блок), зорьтой 8 давхар, 30м*21м (В блок), зорьтой 9 давхар, 30м*21м (С блок) хүчин чадал бүхий аялал жуулчлалын цогцолборын зориулалттай Үйлчилгээ, кинотеатрын барилга байгууламжид Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дугаар захирамжийн шийдвэрээр байгуулагдсан 13 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний 2019/08/30 огноо, 0004767 дугаар; Сунгалтын огноо 2021/11/30


2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар: ӨП-07/2020, IZM-14/02/01;

2.3. Захиалагч: Койнвол ХХК оноосон нэр, 9011037005 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5025842 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11 дүгээр хороо, Зайсан голден вилл оффис 5 давхар, 95014554, 88840070 холбоо барих утас, info@timeholding.mn цахим хаяг;

2.4. Барилгын ажлын гүйцэтгэгч: Тайм холдинг ХХК оноосон нэр, 9011255104 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5418437 регистрийн дугаар, БУ18-338/20 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11 дүгээр хороо, Зайсан голден вилл оффис 5 давхар, 95014554, 88840070 холбоо барих утас, info@timeholding.mn цахим хаяг;

2.5 Барилгын ажлын туслан гүйцэтгэгч байгууллага: Ган эсэн констракшн ХХК оноосон нэр, 9011345063 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5589002 регистрийн дугаар, БУ11-462/23 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 4 дүгээр хороо, 2-р хороолол, 2-1 тоот; холбоо барих утас:96000080

Түшигт буурь ХХК оноосон нэр, 9011854630 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 8394121 регистрын дугаар,



Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 15-р хороолол, Г.Лувсанцэвээн, 57а 205 тоот; холбоо барих утас: 88051092

Макс шил ХХК оноосон нэр, 9011425066 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5732824 регистрын дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 16-р хороолол, энхтайвны өргөн чөлөө гандан байр 35 тоот, холбоо барих утас: 80002727

2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: ИЗМНЭГ ХХК оноосон нэр, 9011105066 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5144973 регистрийн дугаар, ЗТ16-426/24 зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, их сургуулийн МУБИС-4 111, 91993390 холбоо барих утас, info@izmone.com цахим хаяг;

2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: Аймакс стар ХХК оноосон нэр, 9011831223 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6752748 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул, 11 дүгээр хороо, Зайсан голден вилл оффис 5 давхар, холбоо барих утас: 95014554, 88840070 цахим хаяг: info@timeholding.mn;

2.8. Барилга байгууламжийн төлөв байдал: Шаардлага хангасан;

Гурав. Дүгнэлтийн хэсэг

✓ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

□ Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул
- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1 Энэ дунд төвөгшилтэй ангиллын зорьтой 7 давхар, 47.7м*26.7м (А блок), зорьтой 8 давхар, 30м*21м (В блок), зорьтой 9 давхар, 30м*21м (С блок) хүчин чадал бүхий аялал жуулчлалын цогцолборын зориулалттай Үйлчилгээ, кинотеатрын барилга байгууламж түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

Энэ барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.



3.2 Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

- а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад 14 хоногийн дотор багтаан шилжүүлэх;
- б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.3 Ашиглагч байгууллагад:

- а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;
- б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;
- в) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

3.4 Комиссын акт ... хуудас, хуралдааны тэмдэглэл ... хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт ... хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох ... хавтас хуудас материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1 Дунд төвөгшилтэй ангиллын зорьтой 7 давхар, 47.7м*26.7м (А блок), зорьтой 8 давхар, 30м*21м (В блок), зорьтой 9 давхар, 30м*21м (С блок) хүчин чадал бүхий аялал жуулчлалын цогцолборын зориулалттай үйлчилгээ, кинотеатрын барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

Хан-Уул дүүргийн 11 дүгээр хороо, "Койнвол" ХХК-ийн захиалгатай
Аялал жуулчлалын цогцолбор 3 блок барилга


Комиссын дарга: Хяналт шалгалтын
газрын Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч

(А.Мөнгөн)

Нарийн бичгийн дарга:
Койнвол ХХК-ийн Гүйцэтгэх захиарл

(Д.Эрдэнэ)

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын
биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.



ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 11 ДҮГЭЭР ХОРОО, КОЙНВОЛ ХХК-ИЙН ЗАХИАЛГАТАЙ
ЗООРЬТОЙ 7 ДАВХАР А БЛОК, ЗООРЬТОЙ 8 ДАВХАР В БЛОК,
ЗООРЬТОЙ 9 ДАВХАР С БЛОК АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЗОРИУЛАЛТТАЙ
3 БЛОК ҮЙЛЧИЛГЭЭ, КИНО ТЕАТРЫН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ
АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 12 дугаар сарын 27

Улаанбаатар хот

Хан-Уул дүүргийн 11 дүгээр хороо, Койнвол ХХК-ийн захиалгаар баригдсан зоорьтой 7 давхар, 47.7м*26.7м (А блок), зоорьтой 8 давхар, 30м*21м (В блок), зоорьтой 9 давхар, 30м*21м (С блок) аялал жуулчлалын цогцолборын зориулалттай үйлчилгээ, кинотеатрын 3 блок барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын хуралдаан тус барилгын А блокийн 5 давхрын хурлын танхимд 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 13:00 цагт 15 гишүүний бүрэлдэхүүнтэй эхэлж, 15:30 цагт дуусав.

Хуралд:

Комиссын дарга:

- | | |
|---|-----------------|
| 1. Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч | Б.Батчимэг |
| Комиссын нарийн бичгийн дарга: | |
| 2. Койнвол ХХК-ийн Ахлах инженер | Б.Мөнгөн-Эрдэнэ |
| 3. Нийслэлийн Хяналт шалгалтын газрын Барилгын стандарт аюулгүй байдлын хяналтын хэлтсийн дарга, Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч | Г.Батбаатар |
| 4. Нийслэлийн Хяналт шалгалтын газрын Дэд бүтцийн стандарт хяналтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын байцаагч | Э.Цогзолмаа |
| 5. Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн Техник хяналтын хэсгийн ахлагч | Б.Дашдорж |
| 6. Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ийн Шинэ хэрэглэгчийн холболтын албаны дарга | Д.Сүхбат |
| 7. Ус сувгийн удирдах газар, Хэрэглэгчдэд үйлчлэх албаны менежер | Д.Болормаа |
| 8. Технологийн удирдлага төлөвлөлтийн газар, Дэд бүтэц төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн | М.Жаргалан |
| 9. Онцгой байдлын ерөнхий газрын Барилгын зураг төслийн хяналтын тасгийн дарга, дэд хурандаа | Б.Мягмаржав |
| 10. Барилгын хөгжлийн төвийн Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтсийн инженер | О.Ундрах |
| 11. Үндэсний төв архивын Зураг төслийн баримтын архивын ахлах архивч | Э.Шижиртуяа |
| 12. Ашиглалт хариуцах "Аймакс стар" ХХК-ийн Үйл ажиллагаа хариуцсан захирал | П.Даваажаргал |

- | | |
|---|--------------|
| 13. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хамгаалах байгууллагын Монголын тэргэнцэртэй иргэдийн холбооны хүртээмжийн үнэлгээний ажилтан | Б.Даваасүрэн |
| 14. Гүйцэтгэгч Тайм холдинг ХХК-ийн Гүйцэтгэх захирал | Д.Эрдэнэ |
| 15. Зураг төсөл зохиогч ИЗМНЭГ ХХК-ийн захирал | О.Амартүвшин |
| Зураг төсөл зохиогч Өрнөлпроект ХХК-ийн захирал | Ш.Оюундарь |

ИРЦИЙН БАЙДАЛ:

Мэдэгдэл хүлээн авсан – 15
Хуралд оролцож санал гаргасан - 15

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Хан-Уул дүүргийн 11 дүгээр хороонд Койнвол ХХК-ийн захиалгаар баригдсан зоорьтой 7 давхар (А блок), зоорьтой 8 давхар (В блок), зоорьтой 9 давхар (С блок) аялал жуулчлалын цогцолборын зориулалттай үйлчилгээ, кино театрын барилгын барилгын ажлын гүйцэтгэл ашиглалтад оруулах шаардлага хангасан эсэх талаар хэлэлцэв.

Комиссын дарга ирц бүрдсэнийг онцолж хурлыг нээж, хурлын дэгийг танилцуулснаар барилгын үзлэг, шалгалт эхлэв.

СОНССОН НЬ:

Комиссын бүрэлдэхүүнд томилогдон ажилласан гишүүд барилга байгууламжийн зураг төсөл, баримт бичиг, барилгын ажлын гүйцэтгэлийг хянаж танилцаад дараах саналуудыг гаргав.

Захиалагч “Койнвол” ХХК-ийн гүйцэтгэх захирал **Д.Эрдэнэ:**

- Комиссын гишүүдийн үүрэг даалгаварын биелэлтээр байнгын ашиглалтанд өгөх

“Аймакс стар” ХХК-ийн Үйл ажиллагаа хариуцсан захирал **П.Даваажаргал:**

- Комисс орж танилцсан. Үйл ажиллагаа эхлүүлж, комисс хүлээн авахад саналгүй. Хүлээж авахыг хүсч байна.

Зураг төсөл зохиогч ИЗМНЭГ ХХК-ийн захирал **О.Амартүвшин:**

- Барилга бүтээцийн угсралтын ажлыг баталгаажсан зураг төслийн дагуу хийж гүйцэтгэсэн бөгөөд уг барилгыг ашиглалтанд хүлээн авах саналтай байна.

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай.

Нийслэлийн Хяналт шалгалтын газрын Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн дарга, Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч

Г.Батбаатар:

- Барилгад хэрэглэсэн бетоны шинжилгээг үе шат бүрээр үзүүлэх А,В,С блок, суурь
- Барилгад хэрэглэсэн арматурын шинжилгээг үзүүлэх
- ХБИ-нд зориулсан АЦӨ-нд тоноглол хийх
- Барилгын лифт /5ш/ магадлалд оруулсан дүгнэлт үзүүлэх

- Барилгын эскалятор магадлалд оруулсан бичиг үзүүлэх
- Зураг төсөл зохиогч, захиалагч нар БУАГТэмдэглэлийг бүрэн баталгаажуулж үзүүлэх.

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай.

Нийслэлийн Хяналт шалгалтын газрын Дэд бүтцийн стандарт, хяналтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын байцаагч **Э.Цогзолмаа:**

- Гадна дулааны худгийг цэвэрлэж, дулаалга хийж бэхлэх
- ҮДДТ-ийн шугам сүлжээг цэвэрлэж, хаягжуулах
- Халаах хэрэгслүүд дээр термостат суурилуулах
- Халуун хүйтэн усны тоолуур, шугамыг далд хайрцаглах
- Давхар бүрийн АС-ийн системийн угсралтын ил далд ажлыг бүрэн баталгаажуулж шалгуулах
- Дотор халаалтын угсралтын ил далд ажлын акт шалгуулах

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай.

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн Техник хяналтын хэсгийн ахлагч

Б.Дашдорж:

- Гадна цахилгааны дэд өртөө барилгын хооронд хаалт хашлага хийх /эрчим хүчний хамгаалалтын зурвас зөрчсөн/
- Гадна цахилгааны дизель генераторын холболт гүйцээн холбож харъяа ашиглалт, засварын төвд бүртгүүлэх
- 0.4кВ-ын ерөнхий щит 11,12 дугаарын щитний тоолуур хэмжих хэрэгслийн мэдээллийг харах боломжтой заалтны цонх гаргах.

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай.

Улаанбааар дулааны сүлжээ ТӨХК-ийн Шинэ хэрэглэгчийн холболтын албаны дарга **Д.Сүхбат:**

- Халаах хэрэгсэлд тохируулах вентел тавих
- УДДТ хаягжуулалт хийх, гялгар уут авах
- Гадна дулааны худагт цэвэрлэгээ хийх, таг бэхлэх

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай.

Онцгой байдлын ерөнхий газрын Барилгын зураг төслийн хяналтын тасгийн дарга, дэд хурандаа **Б.Мягмаржав:**

- Зоорийн давхрын ХАС-ын зургийг зохиогч баталгаажуулах
- Зоорийн давхрын гал түймрийн үеийн утаа зайлуулах, агаар өгөх системийн автомат ажиллагааг бүрэн хангуулж, актаар баталгаажуулах
- А, В, С блок барилгын гал түймрийн үеийн утаа зайлуулах болон агаарт өгөх системийн ил далд ажлын акт нөхөж үзүүлэх, хүчин чадлыг хэмжих хавхалга тус бүр дээр утаа хаях хоолойг нормын дагуу хийх
- Гал унтраах автомат системийн бүрэн ажиллагааг хангах, удирдлагын зангилааг бүрэн хийх, Б1 давхарт хошууны өндрийн түвшинг хамаарал бүхий шугам хоолойноос зөрүүлэх
- А, В, С блок барилгын 1-4 давхарт байрлах шатны хонгилд дутуу галын хаалга гүйцээж хийх

- Галын дохиоллын системийг цахилгаан шат, урсдаг шаттай автомат холболт хийх. /Галаас хамгаалах хаалт бүрэн ажиллагаанд оруулах/
- В202, А202, С202 шатны хонгилд тусгаарлах материалыг нормын шаардлага хангуулах
- А, В, С блокийн дээвэрт хийгдсэн сендвич материал, спринклер, галаас хамгаалах хаалт, хошууг гамшиг судлалын үндэсний хүрээлэнд шинжилгээнд хамруулах.

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай.

Барилгын хөгжлийн төвийн Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтсийн инженер **О.Ундрах:**

- Шатны арматурчилал зураг төслийн дагуу гүйцэтгээгүй. Зохиогч байгууллага тооцоо гаргаж тайлбар, баталгаа албан бичиг ирүүлэх
- 1, 2, 3-р давхраас бусад давхрын бетоны бат бэхийн дүгнэлтийг блок, давхар тус бүрээр нь нөхөж үзүүлэх
- 4, 5, 23, 24, 25 дугаартай авто зогсоолуудад утаа сорох системийг угсрах
- Барилгын тухай хуулийн 5.7.1-д заасны дагуу норм, нормативын төлбөрийг тооцуулж, төлөх

Өгсөн үүрэг даалгавар биелсэн тохиолдолд ашиглалтад оруулах саналтай.

Үндэсний төв архивын Зураг төслийн баримтын архивын ахлах архивч **Э.Шижиртуяа:**

- Ил далд ажлын актыг бүрэн бүрдүүлэх, баталгаажуулах
- Барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн тэмдэглэлийг гүйцэтгэгч байгууллага баталгаажуулах
- Архивд баримт бичиг хүлээлгэн өгөх нийтлэг жагсаалтын дагуу баримт бичгийг бүрэн бүрдүүлэх, баримт бичгийн хуудас дугаарлах, дотоод товъёог үйлдэх
- Баримт бичиг болон ажлын зургийн эх хувийг архивд хүлээлгэн өгөх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хамгаалах байгууллагын хүртээмжийн үнэлгээний ажилтан **Б.Даваасүрэн:**

- Гадна ХБИ-ны автомашины зогсоолд босоо тэмдэглэгээ хийх, рамп хийх
- Явган хүний замд харааны бэрхшээлтэй иргэдийн хөтөч замыг стандартын дагуу хийх
- Явган хүний замаас рампуудыг стандартын дагуу хийх
- Гадна үүдний налуу замуудад 2 талдаа ижил бариул хийх, халтирхаас сэргийлсэн наалт наах
- Театрын хэсэгрүү орох налуу замыг стандартын дагуу болгож засах, тайзруу налуу зам хийх, үзэгчдийн суудалд орон зай төлөвлөх
- 5-аас дээш давхруудад ХБИ-ий АЦӨ-г стандартын дагуу хийх /тоноглох/
- Цахилгаан шатнуудад зарлан мэдээлэгч буюу давхар зарлагч суурилуулах
- ХБИ-нд зориулсан АЦӨ-үүдийн тоноглолыг зөв болгож засах

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай.

Технологийн удирдлага төлөвлөлтийн газар, Дэд бүтэц төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн **М.Жаргалан:**

- ХД дутуу ажлуудыг гүйцээх
 - Холбоо дохиоллын угсралтын схем зураг гүйцэтгэгч компани гаргаж захиалагчид хүлээлгэж өгөх
 - Давхрын босоо шугамуудыг далдлах
- Үүрэг даалгаврын биелэлтээр хүлээж авах саналтай.

Ус сувгийн удирдах газрын Хэрэглэгчид үйлчлэх төвийн менежер **Д.Болормаа:**

- Холбогдох бичиг баримт бүрдүүлж гэрээ байгуулах
 - УСУГ-аас олгодог техникийн нөхцөл,
 - Гадна шугам, сүлжээний батлагдсан ажлын зураг,
 - далд ажлын акт,
 - ХМС-д бүртгэгдсэн гүйцэтгэлийн зураг
- Цэвэр усны узельд ус зайлуулах трап угсрах, гаргах
- Нийтийн хоолны үйлчилгээ явуулах ресторан, лоунжны гал тогооны тоноглолд стандартын дагуу тос баригч суурилуулах
- Автомашины фандусаар борооны ус В1 давхарт орж БУШ-р зайлуулагдах нөхцөл үүссэн байна. Иймд фандусаар борооны ус нэвтрэхгүй болгох УСУГ-с техникийн нөхцөлгүй, зөвшөөрөлгүй бохир усны системд холбогдсон тул санал өгөхөөс татгалзаж байна.

Гүйцэтгэгч Таймхолдинг ХХК-ийн Гүйцэтгэх захирал **Б.Баттулга:**

Комиссын гишүүдийн өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж ашиглалтад оруулах саналтай.

Зураг зохиогч Өрнөл проект ХХК-ийн захирал **Ш.Оюундарь:**

- ХБИ-н ариун цэврийн өрөөний тоноглол хийх
- Галын шатны хаалганд /зарим давхарт/ нэвтрэх кодтой төхөөрөмж суулгасан байгааг нь зугтах үед саадтай тул чөлөөлөх
- Барилга угсралтын ажлын зураг төслийн дагуу өгсөн зөвлөмж, үүрэг даалгаварыг биелүүлж гүйцэтгэсэн гэж үзэж байгаа тул барилгыг байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.
- Дээрх өгсөн зөвлөмжийн дагуух засварыг хийж гүйцэтгээрэй.

Койнвол ХХК-ийн ахлах инженер **Б.Мөнгөн-эрдэнэ:**

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай.

Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч **Б.Батчимэг:**

- БТХ-ийн 14.3 14.6 заалтын дагуу чанарын баталгаа албан бичгээр ирүүлэх
 - БНБД 11-04-16 дагуу зохиогч дүгнэлт шинэчлэн ирүүлэх
- Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Хан-Уул дүүргийн 11 дүгээр хороонд Койнвол ХХК-ийн захиалгаар баригдсан зоорьтой 7 давхар (А блок), зоорьтой 8 давхар (В блок), зоорьтой 9 давхар (С блок) аялал жуулчлалын цогцолборын зориулалттай үйлчилгээ, кино театрын барилгыг ашиглалтад оруулах, комиссын гишүүдийн өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, биелэлтээр комиссын дүгнэлтийг баталгаажуулж ашиглалтад оруулахаар шийдвэрлэв.

Танилцсан:

Хяналт шалгалтын газрын
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч



/Б.Батчимэг/

Тэмдэглэл хөтөлсөн:

Комиссын нарийн бичгийн дарга:
Койнвол ХХК-ийн Гүйцэтгэх захирал



/Д.Эрдэнэ/